



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 530

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2020 оны эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар 6.09 га газрын эзэмших эрхийн болон 33.03 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирал Б.Батцэнгэл нарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төрийн өөрийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;

2.3. Эрдэм шинжилгээний болон бусад орлогоор үндсэн хөрөнгө бэлтгэхдээ тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах;

2.4. Налайх дүүргийн 2 дугаар хороонд байрлалтай сургалт үйлдвэрлэлийн зориулалттай 3.09 га газрыг сургуулийн нэр дээр шилжүүлж авах ажлыг шуурхай зохион байгуулах;

2.5. Тус сургуулийн эзэмшиж байгаа төмс, хүнсний ногооны зориулалттай 3.0 га газрын эзэмших эрхийг үнэлж, 2021 оны санхүүгийн тайланд тусгах;

2.6. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээслүүлэхдээ Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх тухай 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг баримтлан ажиллах;

2.7. Үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал, нэр, нэршлийг зөв оновчтой бүртгэх, хөрөнгийг эд хариуцагч бүрээр карталж, эзэнжүүлэх, эд хариуцагчтай хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулах, агуулахыг төрөлжүүлэх, эмхлэн цэгцлэх;

2.8. Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг болон ашиглалтын хугацааг

132001444

шинэчлэн тогтоох санал боловсруулж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх;

2.9. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

2.10. Тогтоолын биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн
 530.. дугаар тогтоолын хавсралт**

**Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг
 арилгах арга хэмжээний жагсаалт**

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалт хамгаалалт эмх цэгцгүй	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 3 дахь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны ажиллах журам”
2	Эрдэм шинжилгээний ажил, төслийн ажил гүйцэтгэхдээ тухайн ажилд шаардлагатай үндсэн хөрөнгө худалдан аваадаа холбогдох зөвшөөрөл аваагүй	33.03 сая.төг	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.4 дэх хэсэг
3	Машин тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшлыг санхүүгийн тайланд тусгахдаа НБББББ-т заасан ашиглалтын хугацаанаас өөрөөр бүртгэсэн	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дох заалтыг мөрдөж ажиллах.
4	Сургуулийн 3 дугаар давхарт кофе шопийн зориулалтаар байр талбайг оюутны зөвлөлд ашиглуулан, ямар нэгэн түрээсийн болон ашиглалтын зардал аваагүй	-	Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрэслүүлэх журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай”, 50 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” мөрдөн ажиллах
5	Налайх дүүргийн Засаг даргын тамгын газрын нэр дээр бүртгэлтэй Улаанбаатар хотын Налайх дүүргийн 2-р хороонд байрлалтай 3.09 га сургалт үйлдвэрлэлийн зориулалттай газрыг өөрийн нэр дээр шилжүүлэн аваагүй.	3.09 га	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” А-1/3549 дүгээр албан бичиг
6	Налайх дүүргийн 3 дугаар хороонд байрлах төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн зориулалттай газрыг үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй	3.00 га	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол
Нийт дүн /мөнгөн дүнгээр/		33.03 сая.төг	
Нийт дүн /газрын хэмжээгээр/		6.09 га	